

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
05 ДУГААР САРЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.06.06

Алтай хот

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийгмийн үйлчилгээг бодитойгоор бий болгох, хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, салбар бүрийн оролцоог хангасан нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн асуудлын гарц шийдлийг хэлэлцэх зорилгоор хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн “Нэгдүгээрт хүүхэд” зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Прокурорын газар, Цагдаагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн зөн” ОНХХ-тэй хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд Сумдын Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, нийгмийн бодлого хариуцсан нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, 18 сум 2 тосгоноос 100 хүүхэд, нийт 280 хүн оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл, мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс хамтран 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал явуулын хурлыг бүсчлэн зохион байгуулж ажиллалаа. Урд бүсийн сумдын хурлыг Бигэр сумд 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цээл, Халиун сумдын 45 хүүхэд оролцон, 24 хүүхдэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө өгсөн, 5 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 1 хүүхдийг шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг нээн илрүүлж, 17 хүүхдийн байнгын асаргааны хугацааг сунгаж ажиллалаа. Хойд бүсийн сумдын хурлыг Баян-Уул сумд 05 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулж Баян-Уул, Тонхил, Хөхморьт, Жаргалан, Дарив, Шарга сумдын 33 хүүхэд оролцон, 7 хүүхдэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө өгсөн, 6 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 4 хүүхдийг шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг нээн илрүүлэн, 16 хүүхдийн байнгын асаргааны хугацааг сунгаж ажилласан.

Хүүхдийн орчны аюулгүй байдлын үзлэг шалгалт хийх ажлыг аймгийн Засаг даргын 2022 оны А/303 дугаар захирамжийн хүрээнд зохион байгууллаа. Есөнбулаг сумын хэмжээнд байгаа 11 хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдалд шалгалт хийхэд, нийт 78 тоглоомын 70 хувь нь шаардлага хангахгүй байгаа тул засаж сайжруулах арга хэмжээ авч ажиллах талаар холбогдох багийн Засаг дарга нарт хугацаатай үүрэг, чиглэл хүргүүлээ.

Хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулах, хүний эрхийн стандартыг нэвтрүүлэхэд иргэд, төрийн байгууллагын албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох талаарх “Жендер ба хүний эрх” сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтыг Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Энхболд, ахлах референт Х.Цэцгээ, ХУИС-ийн харьяа “Билэг” дээд сургуулийн захирал, доктор, профессор, Б.Өлзийсайхан болон Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь мэргэжилтэн хамтран зохион байгуулсан бөгөөд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар, агентлаг, шүүх, прокурорын байгууллагын албан хаагчид хамрагдлаа.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “E Mongolia” академийн хамтарсан баг тус аймагт ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр түргэн шуурхай үзүүлэх зорилгоор Говь-Алтай аймгийн 11 байгууллагын нэг болон олон шатлалт нийт 51 төрлийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E Mongolia”-д шинээр нэвтрүүллээ. Тус үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ болон төрийн албан хаагчид, цахим үйлчилгээний операторууд, иргэдэд зориулсан сургалтуудыг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу аймгийн Онцгой байдлын газарт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг эрчимжүүлж, хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, байгаль хамгаалагч нарын хариуцлагыг өндөржүүлэх, ард иргэдэд хүргэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах ажлын чиг үүрэг өглөө.

Боловсрол, шинжлэх ухааны яамны дэд сайд Г.Ганбаяраар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллаж боловсролын салбарын албан хаагчдад төсвийн шинэчлэлийн бодлогыг таниулах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, ойлголт мэдээллийг нэгтгэх, шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх уулзалт-сургалт зохион байгуулж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн 400 гаруй хүн хамрагдлаа.

Төрийн үйлчилгээний чиглэлээр:

Үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах, E-Mongolia төрийн цахим үйлчилгээ, иргэний бүртгэл, халамж, хууль зүйн туслалцаа, наториатын чиглэлээр 5 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 2784 иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллалаа.

Прокурорын байгууллагаас үйлчилгээний нэгдсэн төвийн танхимд дэлгэц байршуулан, цахимаар авч болох үйлчилгээ, мэдээллийн заавар зөвлөмжийг иргэдэд хүргэж байна.

E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр 66 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож, 74 иргэнд төлбөртэй, 177 иргэнд төлбөргүй, нийт 251 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

Үйлчилгээний хураамж болох 59000 төгрөгийг холбогдох дансанд цахим төлбөрийн Q-руу үйлчилгээ ашиглан төвлөрүүлээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулж, 51 иргэний гар утсанд e-mongolia applicatoin-г суулгаж, 116 иргэнд лавлагаа тодорхойлолтыг үнэ төлбөргүй гарган, нэг шатлалаар богино хугацаанд төрийн үйлчилгээг авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.

Өргөдөл гомдлын талаар:

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргад 13, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад 13, нийт 26 өргөдөл бичгээр ирснээс шийдвэрлэлт 50 хувьтай байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 40 иргэнээс ирүүлсэн санал, гомдлыг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлт 72.5 хувьтай байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

2021 оноос 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар гарсан Засгийн газрын 22 хуралдааны тэмдэглэлийн 37 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын new.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд оруулан баталгаажууллаа. Дээрх шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой хяналт-шинжилгээний тайланг боловсруулж, зөвлөмжийг 2022.05.24-ний өдрийн 10/681 дүгээр албан бичгээр холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлээ.

“Сахилга хариуцлага, манлайлал” уриан дор 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан Тайшир сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнд оролцож, шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын талаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд батлагдсан 6 бодлогын 14 чиглэлийн 14 зорилтын 75 арга хэмжээ тус бүрийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд шивж байршууллаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гарсан Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Тус зарлигийн хэрэгжилтийн дундаж 90 хувьтай байгаа бөгөөд 6 заалт 100 хувь, 3 заалт 70 хувьтай хэрэгжиж байна.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний төсвийн ерөнхийлөн захирагчийн хамтран хэрэгжүүлэх 12 арга хэмжээний хэрэгжилтийг хяналаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх газар тариалантай холбоотой 3 хуулийн 5 заалт, Засгийн газрын 2 тогтоолын 8, нийт 5 шийдвэрийн 13 заалтын хэрэгжилтийг хяналаа.

Салбарын сайд нарын аймгийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2022 онд хэрэгжүүлэх гэрээний заалтын тоо, хэрэгжилтийг тайлагнах хугацааг жагсаалтаар гаргаж, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмжийн хамт хүргүүлээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хууль, эрх зүйн чиглэлээр:

2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр холбогдох агентлаг, хууль зүйн туслалцааны төв, нотариат, өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран хуульчийн “Про Боно” өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа өгч ажиллалаа. Аймгийн Прокурор, Цагдаагийн газраас “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгууллаа.

Аймгийн олон нийтийн “Алтай” радиогоор Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэгдсэн найруулгын талаар иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрээр бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, баяжилт өөрчлөлтийг тогтмол хийн, хууль тогтоомжийн лавлагааны сан, эрх зүйн нэгдсэн системээс удирдлага, албан тушаалтан, байгууллага, иргэдэд лавлагаа өгч, бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Архивын чиглэлээр:

Архивын ерөнхий газартай хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын талаар сумдын төрийн байгууллагын архив, албан хэрэг хариуцсан ажилтнуудад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулан 173 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, улсын байцаагчийн дүгнэлт, албан шаардлага хүргүүлээ.

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 70 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын лавлагаа олгон, төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 541000 төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд шилжүүлээ. Мөн 4 иргэний хүн ам, орон сууцны тооллогын лавлагааг <https://e-archives.gov.mn> системээр захиалан хариуг олголоо.

Цахимжуулалт хариуцсан ажилтнууд нийт 4360 хуудас баримтыг скайнердаж, 4197 хуудас баримтыг Photoshop программаар сэргээж, акробат хийж, 2143 хуудас баримтыг e-document.gov.mn программд холболт хийлээ. Архивын ерөнхий газрын e.document.gov.mn цахим системд 404 хөмрөгийн байгууллагын бүртгэл, нэрийн өөрчлөлтийг баталгаажууллаа. Мөн 239 хадгаламжийн нэгжийн бүртгэл хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр:

Нийт 498 гүйцэтгэх баримт бичгийн 3,594,099,500 төгрөгийг биелүүлэхээс 208 гүйцэтгэх баримт бичгийн 390,036,000 мянган төгрөгийг бүрэн дуусгавар болгож 375,867,700 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж 290 гүйцэтгэх баримт бичгийн 2,828,193,800 төгрөгийн үлдэгдэлтэй бодит биелэлт 41.7 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлэг нийт 113 гүйцэтгэх баримт бичгийн 146,121,000 төгрөгийг биелүүлэхээс 4 гүйцэтгэх баримт бичгийн 7,496,800 төгрөгийн тэтгэлгийг дуусгавар болгон, 61 тэтгэлгийн 41,714,200 мянган төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 109 гүйцэтгэх баримт бичгийн 96,910,200 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 30.1 хувьтай байна.

Шийдвэр гүйцэтгэлийн системд мэдээллийг илгээн 26 иргэн, 41 хуулийн этгээдийн өр төлбөргүйн талаарх лавлагааг гарган, иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчиллээ.

Түдгэлзүүлсэн 29 гүйцэтгэх хуудасны 636,071,800 төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байгаагаас 1 гүйцэтгэх баримт бичгийн 359,674,900 төгрөгийн төлбөрийг шүүгчийн захирамжийн дагуу сэргээн ажиллагаанд оруулж шүүхээр шийдвэрлэгдээгүй 4 материал, хаяг тогтоогдохгүй төлбөр төлөгч нарын хаяг тогтоох ажиллагааг цагдаагийн байгууллагын ASAP санд бүртгүүлэн хамтран ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр:

Эрүүгийн хэрэгт мөрдөгч, прокурорын тогтоолыг үндэслэн эрх бүхий бусад байгууллага албан тушаалтны хүсэлтээр 1 криминалистикийн шинжилгээ, мөрдөгч, прокурорын тогтоолоор 3 хэргийн газарт 20 үзлэг, хүний амь нас хохирсон 8, хулгайлах 1, зам тээврийн осол 8, бусад 3, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтын тоо 42, гутлын мөр 2, тээврийн хэрэгслийн мөр 22, бусад ул мөр, эд мөрийн баримт 16, шүүх эмнэлгийн шинжилгээ 38, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 32, цогцост хийсэн шинжилгээ 6 байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийж байна. Лавлагаа олголт-287 гадаад паспорт захиалга-52 хийгдсэн.

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 281 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэв. Иргэд хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамж 2,846,055 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 164,784 төгрөг, татварын орлого 24,775,360 төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Шинээр бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээ авсан 7, дахин олгосон 93, нийт 101 гэрчилгээг бүртгэв.

Тус хугацаанд Иргэний улсын бүртгэлийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тогтоосон журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 101 хүнд 2,020,000 төгрөгийн торгууль ногдуулсан. Иргэний бүртгэлийн чиглэлээр-57, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-8, Хуулийн этгээд-5, нийт иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлд засвар өөрчлөлт оруулах бүртгэл хүчингүй болгох 70 дүгнэлтээр бүртгэлийн зөрчлийг арилгаж шийдвэрлэлээ.

Статистикийн чиглэлээр:

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 4 сарын бюллетень танилцуулгыг хэвлэн гаргалаа.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн 2022 оны 5 сарын мэдээ, том малын зүй бус хорогдлын мэдээ, аж үйлдвэрийн салбарын сарын үйлдвэрлэл, борлуулалтын мэдээг 18 сумын 88 багаас нэгтгэж цуглуулан алдааг засч хугацаанд нь бүрэн боловсруулан дамжууллаа.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

Төсөв санхүүгийн чиглэлээр:

2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймгийн 2022 оны төсвийн тодотголыг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангалаа.

Аудитын Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитын актын төлбөрийг тулган баталгаажууллаа.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Санхүү төрийн сангийн хэлтсийн 2017-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Тусламжийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГААОНӨГ/202205082 дугаартай Цээл сумын шинэ суурьшлын бүсийн худгийн автомат төхөөрөмж, иж бүрэн тохижилтын хамт хийх ажлын тендер, ГААОНӨГ/202205080 дугаартай Есөнбулаг сумын 2-р сургуулийн ариун цэврийн байгууламжийн ажлын тендер, ГААОНӨГ/202205081 дугаартай Есөнбулаг сумын сум дундын дотуур байрны ариун цэврийн байгууламжийн байгууламжийн засварын ажлын тендер, ГААОНӨГ/202205079 дугаартай Есөнбулаг сумын Хантайшир өргөө цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажлын тендер, ГААОНӨГ/202205084 дугаартай Жаргалан сумын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын тендерийг зарлалаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГААОНӨГ/202202047 дугаартай Цогт сумын ариутгах татуургын төв шугам сүлжээний угсралтын ажил, ариутгах татуургын шугам угсрах ажлын тендерийг зарлалаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГААОНӨГ/202203059 дугаартай Хантайширын гудамжны явган хүний авто замыг өргөтгөн шинэчлэхэд шаардлагатай материал худалдан авах ажлын тендер, ГААОНӨГ/202203064 дугаартай Хасагт хайрхан гудамны зам дагуу гэрэлтүүлэг хийх ажлын тендерийг зарлалаа.

Бусад хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГААБИСЗДТГ/202203042 дугаартай Мянгай Бургасны услалтын системийг шинэчлэх засварлах ажлын зураг төсвийн үнэ хийх ажлын тендер "Мөнгөн минж" ХХК шалгарч гэрээ байгуулах эрх, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх ГААОНӨГ/202202050 дугаартай Алтай хотод "Хөгжлийн гудамж" төслийг

хэрэгжүүлэх ажлын зураг төсөл /авто болон дугуйн зам, ус зайлуулах суваг, гэрэлтүүлэг, тохижилт г.м/ ажлын тендерт “Нью Товер” ХХК шалгарч гэрээ байгуулах эрхийг тус тус олголоо.

Орон нутгийн өмчийн чиглэлээр:

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 9-29-ний өдрүүдэд 17 сум, 2 тосгоны орон нутгийн өмчит нийт 115 байгууллагыг хамрууллаа.

Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулж байна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Мал аж ахуйн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 2004 толгой буюу нийт малын 0.07 хувь нь зүй бусаар хорогдож, жилийн эхний тооллогоор аймгийн хэмжээнд 2990.0 мянган толгой мал тоологдсоны 48% буюу 1428.0 мянган эх мал эзэлж байна. Үүнээс 94.7% буюу 1353.0 мянган эх мал төллөх бөгөөд өнөөдрийн байдлаар 86.7 % буюу 1181.3 мянган эх мал төллөж төл бойжилт 99.5% байна. Үүнээс төллөвөл зохих 40.8 мянган гүүнээс 57.1% нь буюу 23.3 мянган гүү, 8.3 мянган ингэнээс 85.0% нь буюу 7.0 мянган ингэ, 28.7 мянган үнээнээс 60.0% нь буюу 17.2 мянган үнээ, 410.0 мянган эм хониноос 91.2% нь буюу 374.3 мянган эм хонь, 876.0 мянган эм ямаанаас 87% нь буюу 759.6 мянган ямаа тус тус төллөөд байна.

Засгийн газрын хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах хүсэлтээ ирүүлсэн 40 гаруй иргэн, 2 аж ахуйн нэгжийн судалгааг гарган ХХААХҮЯаманд хүргүүлсэн.

Газар тариалангийн чиглэлээр:

Сумдаас хаврын тариалалтын мэдээг авч нэгтгэхэд 05 дугаар сарын 20-ны байдлаар 476 га-д ногоон тэжээл, 150 га-д жимс, жимсгэнэ, 28 га-д үр тариа, 10 га-д төмс, 15 га-д хүнсний ногоо, нийт 679 га-д тариалалт хийгдээд байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг улсын хэмжээнд бүх үхэр, гахай, сарлаг, цаа бугыг хамруулан шуурхай зохион байгуулах болсонтой холбогдуулан Улсын онцгой комиссын 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/77 тушаал, аймгийн Засаг даргын А/220 тоот захирамж, Мал эмнэлгийн газрын даргын А/07 тушаалын дагуу шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг хийлээ. Аймгийн хэмжээнд 18 сумын МЭҮН-ийн 48 малын эмч, 9 техникч, 61 туслах ажилтан, 35 удирдах ажилтан нийт 178 хүн ажиллаж, дархлаажуулалтад 82 багийн 4008 өрхийн 60855 үхэр, 151 гахай нийт 61006 толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөснөөс 3554 өрхийн 59182 үхэр, 131 гахай нийт 59313 мал, амьтан хамрагдаж 97.2 хувьтай явагдаж дууслаа.

2021-2022 оны аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдол 5 дугаар сарын 25-ны байдлаар нийт 2004 мал хорогдсон мэдээтэй байна. Одоогийн байдлаар 1004 үхсэн мал амьтны сэг зэм цуглуулж устгаж, хашаа хорооны 20.7 мянган м2, худаг, уст цэгийн 580 м2, бэлчээрийн 400 м2, түүхий эд агуулах цэгийн 205 м2, устгалын цэгийн 4.2 мянган м2, нийтийн эзэмшлийн 9.8 мянган м2, нийт 35.5 мянган м2 талбайд халдваргүйтгэл хийгдээд байна.

ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ,
ДЭД БҮТЦИЙН ХҮРЭЭНД:

Газрын харилцааны чиглэлээр:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлагууд Говь-Алтай аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаатай танилцаж Газрын нэгдсэн удирдлагын цахим системийг нэвтрүүлэн хэрэгжүүлэхтэй холбогдуулан тулгамдаж буй асуудал, аймгийн хот байгуулалтын болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний шинэчлэлт, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын ажиллах нөхцөл зэрэг олон асуудлаар санал солилцож, тодорхой ажлуудыг эрчимжүүлэх талаар үүрэг, чиглэл өглөө.

Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем нь <https://nsdi.gov.mn/> сайтад орж Төгрөг, Шарга, Тайшир, Халиун сумдын нутаг дэвсгэрт батлагдсан нэрсийг мэдээллийн санд тулгалт хийн ажиллаж байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 тушаалаар www.egazar.gov.mn цахим системд 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдлийг цахим болгон ажиллалаа.

Улсын бүртгэлийн тухай шинэчилсэн хуулийн дагуу Газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх болсон ба Аймгийн улсын бүртгэлийн хэлтэст газар эзэмших хувийн хэргийг цахимаар илгээж нийт 8 нэгж талбар газарт Улсын бүртгэлийн Э-дугаар авсан байна.

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүрийн хамгаалалтын бүсийн талбайн солбицлын мэдээллийг аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд шүүлт хийж давхардсан өмчлөл, эзэмшил, ашиглалт байгаа эсэх талаар лавлагааг гарган, аймгийн Соёл, урлагийн газарт хүргүүллээ.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулийн дагуу бусад барьцаалах бүртгэл мэдээллийг 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна.

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зарлах цахим системд бүртгэх чиглэлийг 3 сумын газрын даамалд, газрын биржийн цахим системээр хэрхэн газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаанд оролцох талаар зөвлөгөөг 5 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагад өглөө.

Газрын биржийн системээр газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа оролцогч бүртгэж буй 8, төлөвлөгдөн хүлээгдэж байгаа 13, зохион байгуулагдсан 8 нэгж талбар газрын дуудлага худалдаа зохион байгуулсан байна.

Газрын төлбөрийн системд шинээр олгогдсон болон нэхэмжлэл үүсээгүй 121 нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээлээ.

Цээл сумын Засаг даргын тамгын газар ИТХ-тай хамтран хилийн цэсийн тодотголын ажлыг Рашаантын булаг, Буурын нуурын 1149,2, Буурал хярын овоо, Тооройн нурууны 1304, Сайн цагийн харын зүүн үзүүрийн 1652, Талын хар уул 1978,4 тоот өндөрлөг газруудад хийж гүйцэтгэлээ.

Геодези зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдэд хяналт тавьж, тооллого явууллаа.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулийн дагуу бусдад барьцаалах бүртгэл мэдээллийг 12 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна.

Газар эзэмшигч 6 аж ахуйн нэгж байгууллага, 10 иргэний байршлын кадастрын зураг гаргалаа.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй Төгрөг сумын 100 хүүхдийн дотуур байрны барилга, Тонхил сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Ахмадын холбоо, сувиллын барилга, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй орон нутгийн авто замын босоо болон хэвтээ тэмдэглэгээ хийх ажил, “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” төсөл багц-1 Бигэр сумын ариутгах татуургын төв шугам, цэвэрлэх байгууламжийн угсралт, багц-7 Цогт сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, хувийн хөрөнгөөр хэрэгжиж буй Есөнбулаг сумын “Булган номин уул” ХХК-ийн зочид буудлын барилга зэрэгт ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олголоо.

НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ус, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, хамгаалалтад явцын хяналт хийх, бий болсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах ажлаар Дэлгэр, Чандмань, Бугат, Эрдэнэ, Бигэр, Цогт, Алтай, Тонхил, Дарив, Хөхморьт сумдад ажиллалаа.

Хөхморьт, Тонхил, Шарга, Цээл сумдад улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжиж буй барилга угсралт, их засварын ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэж, мэргэжил ага зүйн зөвөлгөө, шаардлага өгч ажиллалаа.

Чандмань сумын 100 хүүхдийн дотуур байр, 320 хүүхдийн сургууль, Алтай сумын ЗДТГ-аас барилгад ашиглалтын явцад гарсан зөрчлийг арилгуулах тухай шаардах хугацаатай албан бичгийг ажил гүйцэтгэгч компаниудад хүргүүллээ.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн ажлын санхүүгийн гүйцэтгэл цахим системд шилжиж байгаатай холбогдуулан цахим системд нэвтрэх эрх авах тухай хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.

Эрдэнэ сумын сургуулийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулж, зохиогч байгууллагад хүргүүллээ.

Дэд бүтцийн чиглэлээр:

Алтай сумын хэрэглэгчдийг импортын цахилгаан эрчим хүчээр хангахаар Бургастайн боомтоос 84 км цахилгаан дамжуулах агаарын шугам 35/10 кВ-ын 1000кВА чадалтай дэд станцын хамгаалалтын трассыг баталлаа.

Агаарын тээврээр Говь-Алтай-Улаанбаатар чиглэлд 34 зорчигч, 214 кг тээш, 10 ширхэг гар тээшинд аюулгүй байдлын үзлэг хийж нэвтрүүлсэн байна. Улаанбаатар-Алтайн чиглэлд 39 зорчигч, 369 кг тээш ирсэн байна.

Хот хоорондын 93 удаагийн зорчигч тээвэрлэлтээр Говь-Алтай-Улаанбаатар чиглэлд 1339, Улаанбаатар-Говь-Алтай чиглэлд 1389 иргэнд үйлчиллээ.

Автотээврийн техникийн хяналтын үзлэгийн хүрээнд нийт 2912 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас суудлын автомашин-1750, ачааны машин-778, автобус-130, чиргүүл-35, мотоцикл-182, зүтгүүр-17, цистерн-4, механизм-4, тусгай-12 хэрэгсэл байна. Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн-467, эзэмшигч өөрчилсөн-261, хаяж гэсэн тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олголт-12, гэрчилгээ солилт-74, тээврийн хэрэгслийн хасалт-13, автомашины улсын дугаар солилттой шилжилт-100, улсын дугаар солилт-19, мотоциклийн улсын дугаар-9 хасалт- 197, лавлагаа- 32 тус тус олгогдсон.

Ус авах толгойн байгууламж дээр 50096 куб.м түүхий ус олборлож нөөц усны байгууламжаас Алтай хотын иргэдэд 56585 куб.м ус түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламж 39609.5 куб.м бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 3.6 куб.м усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлууллаа.

Цэвэр усны шугам сүлжээ, тоног төхөөрөмжтэй холбоотой 18 дуудлага, бохир усны шугам сүлжээ, тоноглолтой холбоотой 36 дуудлага ирснийг бүрэн шийдвэрлэлээ.

ЗУРГАА. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Эрүүл мэндийн чиглэлээр:

Ковид-19 халдвараас сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх ажлын хүрээнд дархлаажуулалтад хамрагдвал зохих 43485 хүнээс Вакцины 1-р тунд 39286 буюу 90.4 хувь, 2-р тунд 37690 буюу 86.5 хувь, 3-р тунд 16875 буюу 45.1 хувь, 4-р тунд 1860 буюу 4.9 хувь нь хамрагдаад байна. Вакцины нөөц 7264 хүн.тун байна. Ковид-19-ийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ 1030 хүнд хийгдсэнээс 14 тохиолдол батлагдан, батлагдсан тохиолдол 18760 болж, нийт хүн амын 33% коронавируст халдвараар өвчиллөө.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 3457 ор хоног ашигласнаас хүнд өвчтөн 21, нас баралтын 2 тохиолдол бүртгэгдлээ. Амбулаториар нийт 6367 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, төст өвчинтэй 358 тохиолдол бүртгэгдлээ. Нийт 75 эх эсэн мэнд амаржиж, 74 хүүхдийг хүлээн авч, нярайн эндэгдэл 1 бүртгэгдлээ. Нийт 82 мэс засал хийснээс мэс заслын тасагт 49, гэмтлийн тасагт 18, төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 15 байна. Түргэн тусламжийн 318 дуудлагад үйлчилж, яаралтай тусламжийн тасагт 508 хүн ирж үзүүлснээс томуу, томуу төст өвчний 113 тохиолдол бүртгэгдлээ. Алсын дуудлагын 6 тохиолдолд Бигэр, Эрдэнэ, Дэлгэр сумдад үйлчиллээ.

Аймгийн хэмжээнд амбулаториар 12115 үзлэг хийснээс 740 буюу 6.1% нь, яаралтай тусламжийн 534 дуудлага хүлээн авч үйлчилснээс 107 буюу 20% нь томуу томуу төст өвчин бүртгэгдлээ. ТТӨ-өөр өвчлөгсдийн дотор 91.3%-ийг 16, үүнээс 71.6% нь 4 хүртэлх насныхан бүртгэгдсэн байна. 10000 хүн ам дахь ТТӨ-ний 31.4 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 25.3 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

“Эрүүл мэнд үндэсний баялаг” уриатай хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын хүрээнд 17 сум, 2 тосгоны нийт 410 эрчүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Магадлан итгэмжлэлийн хугацаа 2022 оны 8-9 дүгээр сард дуусах эрүүл мэндийн байгууллагуудын материалыг хянан цахим системд байршуулж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” 3843-МОН төслийн гэрээгээр Эрүүл мэндийн стратегийн худалдан авалтын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд 1787.5 мянган төгрөгийн санхүүжилтээр 60 хүнд 2 өдрийн танхимын сургалт, 25 хүнд 3 өдрийн ажлын байрны дадлага, сургалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/16 дугаар тушаалаар “Сувилагчдын бие даасан байдал-Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” сургалтад 2022 оны 05 дугаар сарын 10-12 өдрүүдэд Нэгдсэн эмнэлэг, УАУНЭ, ЗӨСТ, АШУҮИС-ийн ГАА дахь АУС, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн 32 байгууллагын 300 гаруй сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдлаа.

Эрүүл мэндийн газар, АШУҮИС-ийн харьяа сургуультай хамтран баруун бүсийн сувилагч, тусгай мэргэжилтний эрдэм шинжилгээний илтгэл, бүтээл шалгаруулах хурлыг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Баянхонгор, Говь-Алтай 6 аймгийн 19 илтгэлийг хэлэлцүүлж эхний 5 байрыг шалгарууллаа.

АШУҮИС-ийн харьяа ГАА дахь АУС-ийн Мэргэжлийн суурь эрдмийн тэнхмээс санаачлан сувилахуйн клуб хамтран “Эрсдлийн эсрэг хамтдаа” хэлэлцүүлгийг зохион байгуулж 26 байгууллагын 130 гаруй сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдлаа.

ЭМХТ, МСН-тэй хамтран сувилахуйн зөвлөх зэргийн цахим сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 4 сувилагч мэргэшлийн зэрэг хамгааллаа.

УГТЭ-ээс 05 дугаар сарын 12-ны өдөр “Флоренс Найтангелийн сувилахуйн тэмдэглэл” цахим сургалтад 8 байгууллагын 26 сувилагч хамрагдлаа.

“Олон Улсын Сувилагчдын Өдөр”-ийг угтаж ЭМЯ, ДЭМБ, ХСҮТ-өөс “Сувилагчдын бие даасан байдал-сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор “Хавдрын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвт үндэсний сургалтад танхимаар 3, цахимаар 9 нийт 12 сувилагч хамрагдлаа.

ЭМГ-ын даргын 2022 оны А/25 дугаар тушаалын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагуудад магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх цахим сургалтыг зохион байгуулж 19 эрүүл мэндийн төвийн 173 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Эрүүл мэндийн 5 байгууллагын 8 эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгах материалыг HRD программд хянаж, шалгалтад орох 3 сувилагчийн бүртгэлийн системийг үүсгэлээ.

“Дэлхийн тамхины эсрэг өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 5 төрлийн зөвлөмж, шторкийг Говь-Алтай Эрүүл мэндийн газар, Нийтийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаа цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/284 дугаар тушаалаар бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог хийх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт 56 нэр төрлийн 131 ширхэг 2410661.7 мянган төгрөгийн, Зооноз өвчин судлалын төвд 1 нэр төрлийн 1 ширхэг 4000.0 мянган төгрөгийн, Халиун сумын ЭМТ-д 3 нэр төрлийн 12 ширхэг 20087.7 мянган төгрөгийн, нийт 61 нэр төрлийн 2.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авлаа.

Боловсролын чиглэлээр:

“Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрийг улс орон даяар зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын ивээл дор ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар ангийн сурагчдын "Монгол бичгийн анги нийтийн сорилго" уралдааныг 2022.05.05-ны өдөр зохион байгууллаа.

9 дүгээр ангийн сурагчдаас 2022-2023 оны хичээлийн жилд сонгон судлах хичээлийн асуулгыг авч 24 сургуулийн 853 сурагч хамрагдлаа.

Туслах багш нарыг ажлын байранд нь чадавхижуулах онлайн, танхим хосолсон сургалтад 31 цэцэрлэгийн 163 туслах багш хамрагдлаа.

Шинээр үүсгэн байгуулагдсан 320 хүүхдийн хүчин чадалтай Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг дэмжиж, НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр 15 сая төгрөгийн тоглоом наадгай, ном сургалтын хэрэглэгдэхүүн, биеийн тамир, хөгжмийн танхимын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн нийлүүлээ.

Мобиком корпорацитай хамтран хэрэгжүүлж буй SMART EDUCATION 2 төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 6-9 дүгээр ангийн 480 сурагчийн бүтээл ирснээс шилдэг 60 бүтээлийг шалгаруулан А12 маркийн гар утсаар урамшууллаа.

"Алтайн боловсролын хөгжил, менежмент" удирдах ажилтны зөвлөгөөнийг Чандмань сумд зохион байгууллаа.

НҮБ-ын “Хүүхдийн сан”-ийн дэмжлэгээр Говь-Алтай аймгийн Бугат, Жаргалан сумдад хэрэгжиж буй "Эцэг эхийн загвар клуб"-ын үйл ажиллагаатай танилцах, клубын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ, мониторинг хийхээр БШУЯ-ын зөвлөх, МУ-ын Гавьяат багш А.Нармандахаар ахлуулсан төслийн удирдах баг 2022 оны 05 сарын 6-11-ний өдрүүдэд ажиллалаа. Эцэг эхийн загвар клубын үйл ажиллагаанд үнэлгээ өгч, “Аавуудын сонирхлын бүлэг”, “Өвөө эмээгийн сонирхлын бүлэг”-ийн үйл явц болон аймгийн зөвлөх багийн эцэг эхэд зориулсан сургалтын агуулга, сургалтын үр дүн явцад мониторинг хийж, арга зүйн зөвлөгөө өгч, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Засгийн газрын 37 дугаар тогтоолын дагуу их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл бичгийн дахин шалгалтыг зохион байгуулж, 136 шалгуулагч хамрагдахаас 79 шалгуулагч оролцлоо.

2022 оны 05 сарын 23-27-ны өдрүүдэд "Гүйцэтгэлийн үнэлгээ"-г зохион байгуулж 27 сургуулийн 773 багшийн үнэлгээний шалгалтыг авч давхардсан тоогоор 1-12 дугаар ангийн 8132 хүүхэд хамрагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарын дунд ур чадварын уралдааны 2 дугаар шатыг зохион байгуулж, 31 цэцэрлэгийн багш оролцлоо.

Мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулж, 8-11 дүгээр ангийн 132 сурагч хамрагдлаа.

Соёл, урлагийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар, Насан туршийн боловсролын төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран үндэсний бичгээ эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх, төрийн албан хаагчдын монгол бичгийн хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх "Хүмүүн бичиг-хүн бүрийн бичиг" уралдааны эхний шатыг зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хүрээнд бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өвийг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022" арга хэмжээг аймгийн хэмжээнд 2022 оны 05 сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр Нийтийн номын сангаас "Шилдэг уншигч", "Уран бийр" уралдааны шагналыг гардууллаа. Шинэ болон ховор, хуучин ном, М.Цэдэндоржийн ном, "Алтайн хөгжил" сониноор үзэсгэлэн гаргаж уншигчдад сонирхууллаа.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам"-ын хүрээнд Монгол Улсын Соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан 362 өвийн оршин тогтнох чадварыг өвлөн уламжлагчаас цуглуулсан мэдээлэл, мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор тодорхойлох, үнэлэлт өгөх, дүгнэж тайлагнах болон цаашид СББӨ-ийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилготой Соёлын биет бус өвийн улсын үзлэгийг зохион байгууллаа. Гуулин, Дэлгэр, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цогт, Баянтоорой, Халиун сумдын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг бүртгэн баримтжуулж, яаралтай хамгаалах шаардлагатай 20 өвийн бичлэг, гэрэл зургаар баримтжууллаа.

"Соёлт Алтай Хот" урлагийн наадмын нээлтийн үеэр Есөнбулаг сумын ЗДТГ, Соёл урлагийн газар, Музей хамтран иргэдэд хадгалагддаг соёлын өвийн үзэсгэлэнг зохион байгуулж, ховор төрлийн соёлын өв тээн хадгалагчдыг сайшаан, батламж хадгалууллаа.

Олон улсын Музейн өдрийг угтаж Ховд аймгийн музей, Эрдэнэбүрэн сумын Соёлын төвтэй хамтарч "Бошготын өв" сэдэвт үзэсгэлэнг 4 хоногийн хугацаатай зохион байгуулж, Галдан хааны эдэлж хэрэглэж байсан түүхийн нэн ховор 50 гаруй эд өлгийн зүйлс баримтат өвүүд дэлгэгдэж, нийтийн хүртээл боллоо.

Монголчуудын оршихуйн соёлын үнэт өв угийн бичгээ үеэс үед уламжлуулан хөтөлдөг зан үйлийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, цус ойртолтоос сэргийлэх зорилгоор "Цус ойртолт ба угийн бичиг" сэдэвт төлөвлөгөөт сургалтад аймгийн шүүхийн Тамгын газрын 16 албан хаагч хамрагдлаа.

Цогт сумын уугуул АДБ-ийн Алтай чуулгын ахмад уран бүтээлч, ардын болон уртын дууч, соёлын өв тээгч, МУСТА Бүдширийн Гүнчиндоржийн нэрэмжит

Ардын язгуур урлагийн анхдугаар уралдааныг зохион байгуулж, 18 сум, 2 тосгоны нийт 34 ардын авьяастан оролцлоо.

05 дугаар сарын 11-ний өдөр дэлхийн сувилагч нарын 26 дахь жилийн ойн баярт зориулсан сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд “Сувилахуйн эрдмийн дууч” гоцлол дууны уралдааныг зохион байгуулж 32 сувилагч оролцлоо

Нийтийн номын санд 53 шинэ уншигч бүртгэн, 705 ирцэд 765 ном олгож, уншигчдад аман болон бичгийн 11 лавлагаа, 12 татгалзал бүртгэн үйлчиллээ. Гэрээр ном олгох тасаг, Уншлага үйлчилгээний 2 танхимаас нийт 54 ширхэг ном сэргээн засварлаж уншигчдад хүргэлээ. Зөөврийн номын сангаар 3-р цэцэрлэг, ШШГГазарт үйлчлэн, 25 шинэ уншигч бүртгэн, 54 ирцэд 120 ном олголоо.

Аймгийн зохиолч яруу найрагч, уншигч хүүхдүүдийн дунд “Уншигч зохиолчдын чөлөөт ярилцлага” уулзалтыг зохион байгуулж, 5 зохиолч, яруу найрагч, 27 уншигч хүүхэд оролцлоо.

Улсын тэргүүний ардын авьяастан, өв соёл судлаач, ерөөлч, магтаалч Х.Ивансан, МУСТА, зохиолч Х.Батмэнд нарын "Тунамал оршихуй" шинэ номын нээлтийг 5 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, 10 ширхэг номыг фондод авлаа.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд 6903 хүн хамрагдлаа. Идэвхтэй оролцсон байгууллага болон хувь хүмүүсийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооны “Талархлын бичиг”, аймгийн Биеийн тамир, спортын газрын батламж, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.

Монгол улсад Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан ажил олгогч, даатгуулагчдын дунд волейболын тэмцээн зохион байгуулж, эрэгтэй 22, эмэгтэй 26, нийт 48 багийн 380 гаруй тамирчид оролцлоо.

Монголын бүх ард түмний спортын XV наадмын баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн 5 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Завхан аймагт зохион байгуулагдаж эрэгтэй 10, эмэгтэй 9 тамирчин, волейболын тэмцээн 5 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт зохион байгуулагдаж эрэгтэй 8, эмэгтэй 11 тамирчин оролцож, тус аймгийн эмэгтэй баг тамирчид I байранд шалгарч алтан медаль, Монголын бүх ард түмний спортын XV наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.

Монголын Үндэсний спортын VII наадмын ширээний шагай, наадгайн тэмцээнийг 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, 9 багийн 36 тамирчин, насанд хүрэгчдийн ганцаарчилсан төрөлд эрэгтэй 21, эмэгтэй 18, 16 хүртэлх насанд эрэгтэй 29, эмэгтэй 16, нийт 120 тамирчин оролцлоо.

“Мандал голомт” ХХК-ийн 2 төрөлт (волейбол, дартс) тэмцээнд 8 багийн 50 гаруй хүн, Эм холбоо Говь-Алтай салбар, Монос группийн хамтарсан 3 төрөлт (волейбол, ширээний теннис, шатар) тэмцээнд 7 багийн 42 хүн оролцлоо.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, Монголын Хөлбөмбөгийн холбооноос хэрэгжүүлж буй сургуулийн хөлбөмбөг төслийн хүрээнд 2022 оны хөлбөмбөгийн аймгийн аварга шалгаруулах анхны тэмцээнийг аймгийн Биеийн тамир спортын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, аймгийн

хөлбөмбөгийн холбоо хамтран зохион байгуулж, охидын U13 насны ангилалд 7 багийн 50 тамирчин, U15 насны ангилалд 6 багийн 38 тамирчин, хөвгүүдийн U14 насны ангилалд 11 багийн 86 тамирчин, U16 насны 7 багийн 83 тамирчин оролцлоо.

Сувилагч, тусгай мэргэжилтний дунд зохион байгуулсан “Бид хамтдаа-2022” спортын 2 төрөлт тэмцээнд харьяа 28 байгууллагын 224 тамирчид оролцлоо.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:

Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, халамж хүртэгч хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажлын байртай болгох зорилгоор “Халамжаас хөдөлмөрт-100” челанж арга хэмжээний дэвтэр, тугийг 5 дугаар сарын 6-ны өдөр Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, тус газар нь бүтэн өнчин, сургуулийн насны 2 хүүхэд, түүний асран хамгаалагч эмэгтэйг сонгон авч жилийн турш амьдралын чанарыг нь дээшлүүлэх, ажлын байртай болгохоор боллоо. Нийгмийн даатгалын хэлтэс нь Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг дараагийн байгууллагаар дуудсан тул дэвтэр, тугийг хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгууллаа.

Нийгмийн халамжийн багц хууль, хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээний талаар Есөнбулаг сумын 2, 5, 8, 10 дугаар цэцэрлэгт мэдээлэл хүргэж ажиллалаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 46 иргэн, Есөнбулаг сумын 10 багийн иргэдэд тайлант онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээний талаар мэдээлэл хүргэлээ.

“Төрөлх Алтайн хөгжилд-Залуусын оролцоо” өдөрлөгийг 5 дугаар сарын 15-ны өдөр Говь-Алтай аймгаас Улаанбаатар хотод суралцагч, төгсөгч оюутан залуучуудын дунд зохион байгууллаа.

2022 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгох санхүүгийн дэмжлэгийг 5 дугаар сарын 09-19-ний өдрүүдэд зарлалаа. Есөнбулаг сумын тухайд санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 209 иргэн төсөл ирүүлсэн байна. Үүнд: 30-аас дээш хөдөлмөрийн насны 87, хувиараа хөдөлмөр эрхлэгч ахмад настан 34, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 63, ахмадын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй 23, хүүхэд харах үйлчилгээ байгуулах хүсэлтэй 2, нийт 209 иргэн төслөө ирүүлсэн байна.

“Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд 7 сумаас 100 иргэнийг түр ажлын байраар хангах 44,5 сая төгрөгийн өртөг бүхий 12 төсөл ирүүлээд байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Оролцоо” төслийн бүртгэлийг 5 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байна. “Оролцоо” төслийг сурталчлах ажлын хүрээнд мэдээллийг цахимаар түгээхээс гадна 2021 онд тус төсөлд бүртгүүлээд хамрагдаагүй 70 иргэнээс 42 иргэнтэй холбогдож, төслийн талаарх мэдээллийг хүргэж ажиллалаа. .

18-34 насны залуучуудын дунд орон нутагтаа зохион байгуулдаг шилдэг бизнес санааг шалгаруулах “STARTUP” арга хэмжээний бүртгэлийг 5 дугаар сарын 18-ны өдрөөс цахимаар эхлүүлээ.

Оюутан залуучуудад зориулсан арга хэмжээний хүрээнд авсан сул чөлөөтэй ажлын байрны мэдээллээс гадна 6 байгууллагаас ажиллах хүч авахаар албан хүсэлт ирүүлснийг хэвлэл мэдээллийн байгууллага, байгууллагын цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэлээ. Ажлын ярилцлага зохион байгуулсан “Макс рөүд” ХХК 21 хүнээс 3, “Ховд эко цемент” ХХК 20 хүнээс 7 хүнийг ажлын байраар хангалаа.

Ажил, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолтой, ажилгүй иргэдийг “LIMS” системд бүртгэх, бүртгэлийг шинэчлэн сэргээх үйлчилгээний хүрээнд 2022 оны 5 дугаар сарын байдлаар ажил идэвхтэй хайж буй 844 иргэн бүртгүүлсэн ба 384 буюу 45,2 % нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 421 буюу 49,8 хувь нь 15-34 насны иргэд эзэлж байна. 2 иргэн ажилгүйдлийн тэтгэмж авахаар тодорхойлолт авсан ба мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэн мэдээлсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хүний нөөц, нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын тухай шинэчлэгдсэн хууль тогтоомж болон зөвлөмжийн талаар сургалт зохион байгуулж, 105 хүнийг хамрууллаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8905 хүнд ХААН болон Төрийн банкаар 4.4 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан сум, аймгийн төвийн өндөр настан 48, тахир дутуу 18, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3, нийт 69 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 53 хүнд 84.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 53 хүнд 7.7 сая, оршуулгын тэтгэмж 10 хүнд 10.0 сая, ажилгүйдлийн тэтгэмж 31 хүнд 19.5 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 66 хүн хамрагдлаа. Эрүүл мэндийн даатгалд 803 иргэн хамруулж, 31.3 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар нийт 153 хүн орж, шинээр 18 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 143 хүний групп сунгагдаж, 10 хүний групп цуцлагдсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Орон нутгийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”, “Хамтарсан баг”-ийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, цаашид хамтарч ажиллах талбараа тодорхойлох, мэдээлэл солилцох, хүүхдэд хүрч үйлчлэх тусламжийг цаг алдалгүй, чанартай хүргэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 50 хүнийг хамрууллаа.

“Гэр бүл, хүүхдийн чиглэлээр хэрэгжүүлж буй программ ашиглалтын сургалт”-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын баг бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгуулж сум, багийн хамтарсан багийн нарийн бичиг, холбогдох мэргэжилтнүүд нийт 45 хүнийг хамрууллаа.

“Олон Улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Бүх хайраа гэр бүлдээ” залуу гэр бүлд зориулсан сургалтын үйл ажиллагааг Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, “Дэлхийн Зөн” ОНХХ, МСҮТөв, Насан туршийн боловсролын төвүүдтэй хамтран зохион байгуулж, нийт 20 гэр бүлийг хамрууллаа. Үйлчилгээ

эрхлэгч байгууллагуудыг хамруулан “Гэр бүлд ээлтэй үйлчилгээ” challenge-ийг зарлаж, Орон нутгийг судлах музейтэй хамтран “ОУ-ын гэр бүлийн өдөр”-өөр үнэ төлбөргүй үйлчилж, нийт 54 гэр бүлийг хамрууллаа. Монголын эмэгтэйчүүдийн холбооны Говь-Алтай аймаг дахь салбартай хамтран “Аав-Ээж-Би” өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 15 гэр бүлийг хамрууллаа.

Эцэг эхчүүдийн хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголт, гэр бүлтэйгээ өнгөрүүлэх чанартай цаг хугацааг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” арга хэмжээг аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж 30 насанд хүрэгч, 55 хүүхдийг хамрууллаа.

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан гэр бүлийнхээ нандин дурсамжтай, хөгжилтэй агшинг бусадтай хуваалцах, эерэг нөлөөллийг түгээх зорилгоор “Манай гэр бүлийн хөгжилтэй агшин” цахим видео бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд ирсэн видео бичлэгүүд нийт 22054 хандалт авч, 367 удаа бусадтай хуваалцаж түгээсэн байна.

“Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр 15 насанд хүрэгч, 1 хүүхэд үйлчлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр 1 хүүхэд, 1 насанд хүрэгч үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалтад авч ажиллалаа.

Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Мэргэжлийн хяналтын газар, Дэлхийн зөн орон нутгийн хөтөлбөртэй хамтран “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” тусгай арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрт зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог сэдвээр илтгэл тавьж, “Авьяаслаг ээж”, “Авхаалжтай хүүхэд” шалгаруулан, ивээн тэтгэгч байгууллагаас 55 хүүхдэд гарын бэлэг өглөө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч 61 иргэнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгодог хөнгөлөлт, тусламж үйлчилгээ, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрийн танилцуулга, мэдээлэл өглөө.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хүнд нөхцөлд байгаа 5 хүүхдэд дархлаа дэмжих багц, Дэлхийн Зөн Говь-Алтай ОНХХ-тэй хамтран 1 хүүхдэд хүнсний дэмжлэг үзүүлсэн.

“Охидын сарын тэмдгийн өдөр”-ийн хүрээнд өсвөр насны охидод сэтгэцийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн мэдээллийг хүргэх, тулгамдаж буй асуудлаар нь зөвлөн туслах замаар тэднийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт уулзалтыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 8-11 дүгээр ангийн 200 охид, сургуулийн эмч, сэтгэл зүйч оролцлоо.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан байгууллагын дэргэдэх “Өсвөрийн сэтгүүлч” клубтэй хамтран “Хэн сайн мэдэх вэ?” цахим контент, “Мэдлэгийн өртөө” клубтэй хамтран “Том гарууд” 4 цуврал контентыг бэлтгэн, олон нийтэд хүргэлээ.

Есөнбулаг сумын 1, 3, “Хантайшир өргөө” цэцэрлэг, 4-р сургуулийн хүүхдүүдийг хамарсан “Хамтдаа тоглоё” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 80 хүүхэд хамрагдлаа.

Өөрийн болон бусдын эрүүл мэнд, сэтгэл санаа, ёс суртахуун зэрэгт хохирол учруулах хорт зуршлаас ухамсартайгаар татгалзан, бусдад зөвлөн тусалж эрүүл мэндээ дэмжих, хамгаалах аюулгүй амьдрах чадварыг эзэмшүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүмүүжигч 4 иргэнд сургалт зохион байгууллаа.

Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд аймгийн “Өсвөрийн парламент”-ын сурагчдын үйл ажиллагаагаар дамжуулан Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад эрүүл зөв хооллох, мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал зуршилд уриалах, өглөөний цайны ач холбогдлыг таниулах зорилготой “Өглөөний цай”-г өөртөө өдөрлөгийг зохион байгууллаа.

Өсвөрийн Парламентын гишүүдээр төлөөлүүлж өсвөр насныханд эрүүл зөв хооллох мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал зуршилд уриалах, хөтөлбөрөөс олж авсан мэдлэгээ үе тэнгийнхэн, сургуулийнхандаа түгээх эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд “Сургуулийн тогоочдоо тусалъя” үйл ажиллагааг 2 удаа зохион байгууллаа.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХҮРЭЭНД:

Байгаль орчны чиглэлээр:

Тайшир сумын Гэгээн нуур, Хуримт баг, Овоон харын чиглэлд Мэргэжлийн хяналтын газартай хамтран загас агнах, барихыг хориглосон хугацааны болон зэрлэг амьтдын байршил тогтоох, тарвага нутагшуулах боломж бүхий газрын судалгаа, хяналтыг зохион байгууллаа. Хуримт багийн нутаг Бэрхийн нуруунд тарвага нутагшуулах боломж бүхий газрыг тогтоож, цэг байршил, ичээ, эзэнтэй эзэнгүй нүхийг тогтоож, дахин нутагшуулах тооцоо мэдээллийг цуглуулав.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үр ашигт байдлын үнэлгээг (МЕТТ) талуудын оролцоотой хийх ажлыг зохион байгууллаа. Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөлтэй хамтран Бурхан буудай уулын байгалийн нөөц газар, Баянтооройн бүрд орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын үр ашигт байдлын үнэлгээ (МЕТТ) хийх ажлыг Цогт, Бигэр сумдын холбогдох албан тушаалтнууд, нутгийн иргэд, малчид нийт 65 хүний бүрэлдэхүүнтэй гүйцэтгэлээ.

Цөлжилтийг сааруулах зорилгоор Унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн 23,0 сая төгрөгийн санхүүжилтээр Цогт сумын Төгрөг багийн Хаяа нэртэй газарт 10 га талбайд малын тэжээлийн ургамал тариалах ажлыг “Хос-Эрхэс” ХХК-аар гүйцэтгүүлж, сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

“Тэрбум мод” тарих хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх цахим сургалтад 18 сумын холбогдох албан хаагч, тариалан эрхлэгч нийт 54 иргэн хамрагдлаа.

Ус цаг уур орчны шинжилгээний чиглэлээр:

Цаг уурын 6 өртөө, 14 харуулын цаг уурын 04 дүгээр сарын цаг уурын ажиглалт хэмжилтийн тайлан материалыг хүлээн авч цахим хэлбэрт шилжүүлэн техник, шүүмж шалгалт хийж дуусган УЦУОСМХ-д хяналтын хугацаанд нь дамжууллаа.

Тус аймгийн бэлчээрийн ургамлын ургалтын байдал 2022 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 23.7 хувьд сайн буюу ургалт сайн (Есөнбулаг, Бигэр, Гуулин, Төгрөг, Эрдэнэ сум) 31.6 хувьд дунд буюу ургалт удааширалтай (Алтай, Баянтоорой тосгон, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Халиун, Шарга сум) 44.7 хувьд буюу ургалт муу (Тонхил, Бугат, Хөхморьт, Дарив, Дэлгэр, Цогт, Цээл, Чандмань сум) байна.

Мэдээллийн дэд санд мэдээллийн нэгдсэн сангийн нөөц хувь үүсгэх ажил хийгдэж байна. Мөн Есөнбулаг сумын хөрсний бохирдлын 16 цэгийн агро хими болон хүнд металлын дээжийг авч шинжилгээ хийгдэж байна.

НАЙМ.ГАМШГААС ХАМГААЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу “Дашваанжил” ХХК-ийн авто болон ахуйн хий түгээх станцын барилга байгууламжид хяналт шалгалт хийлээ.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх” нэгдсэн арга хэмжээ, “Зөвийг хэвшүүлэе” уриан дор зохион байгуулагдаж буй “Сурагчийн аюулгүй байдалд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо чухал” нөлөөллийн ажил, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, гэр хорооллын айл өрхүүдэд пийшин, зуух, яндангийн аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны заавар, зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх зөвлөмж тараалаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3515 айл, өрхөд хийж, үнс, нурам ил задгай асгасан, гэр хоорондын зай ойр, зуухны өмнө 50x70 см хэмжээтэй хаалт байрлуулаагүй, яндангийн залгаа буруу, цахилгааны угсралт буруу зэрэг нийт 350 зөрчил илрүүлж, газар дээр нь 125 зөрчлийг арилгуулж, багийн Засаг дарга нарт гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 34-39 дүгээр заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлээ.

“Алтай” телевиз, “Алтайн мэдээ” сонин, “Алтайн мэдээ” агентлагтай хамтран иргэдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт, ухуулга сурталчилгааг хийж, 8380 иргэнд зөвлөн тусаллаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хурлыг 05 дугаар сарын 06-ны өдөр, “M-oil” ХХК-тай хамтран гал унтраах тархалтын дадлага, сургуулийг 05 дугаар сарын 10-ны өдөр тус тус зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-Спортын “Дөл” тэмцээнд оролцсон сурагчдад “Хорт хий утаанаас хамгаалах баг”-ны талаар сургалт зохион байгууллаа.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны эмэгтэй сурагчдын дунд хийгдэх эрсдэлийн үнэлгээний асуумж бэлтгэж, 2022-2023 онд Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх аж ахуйн нэгж, байгууллага, сургууль, цэцэрлэгийн судалгааг гаргалаа.

Аймгийн Онцгой комиссын ээлжит 6 дугаар хурлыг зохион байгуулж 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэлээ. Монгол Улсын Шадар сайдтай аймгийн Засаг даргын 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын дадлага сургууль, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийг 9 сумд зохион байгуулах, Шарга сум дахь аймгийн аюулгүйн нөөцийн 1 дүгээр агуулах хүчтэй шуурганы улмаас дээвэр унасанд хөрөнгө гаргах, 2022 онд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны зардал 12,200,000 төгрөгийг аймгийн гамшгийн сангаас гаргахаар тус тус шийдвэрлэлээ.

05 дугаар сард 7048101 утсанд 3 удаагийн гал түймрийн дуудлага ирж, гал унтраах тархалт хийж 6 тонн ус, 42 литр шатахуун зарцуулан гал түймрийг бүрэн унтраалаа. Гал түймрийн улмаас иргэдэд 8.600.000 төгрөгийн хохирол учирч, 13.800.000 төгрөгийн өмч хөрөнгийг аюулаас авран хамгааллаа.

ЕС. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД:

Байгаль орчны хяналтаар:

Наробанчен гэгээний туурь орчимд түүхийн эд өлгийн зүйл хайхыг завдсан 3 иргэний үйлдлийг таслан зогсоолоо.

Мэргэжлийн хяналтын газар, Прокурор, Цагдаагийн газартай хамтран Есөнбулаг сумын Рашаант багийн нутаг Шаврын гол, Өлд хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж, шалгалтад 7 тээврийн хэрэгслийн 8 иргэнийг хамруулан, Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа. Мөн Бигэр сум дахь гурвалсан гэрээгээр ажиллаж байсан бичил уурхайчдын үйл ажиллагаанд шалгалт хийж, илэрсэн зөрчилд 3 заалт бүхий хамтарсан албан шаардлага өглөө. Тус бичил уурхай эрхлэгчид 10.76 га эвдрэлд орсон талбайн 7га-д техникийн нөхөн сэргээлтийг хийж сумд хүлээлгэж өгсөн байна.

Есөнбулаг сумын Баарангийн даваанд зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал /хайрга/ олборлож буй иргэдийн үйл ажиллагаанд мэдээллийн мөрөөр төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор Цагдаагийн байгууллагад шилжүүллээ.

“Хууль бус олборлолтын шалтгаан нөхцөл, үр дагавар, урьдчилан сэргийлэх арга зам ” сэдэвт панел хэлэлцүүлэгт оролцож, уул уурхайн олборлолтын нөхцөл байдал, тухайн аймаг тус бүрт ямар байгаа болон хууль бус олборлолтын нөхцөл байдал, шалтгаан, үр дагаврын талаар мэдээлэл хийж оролцон, цаашид авах арга хэмжээний саналаа хүргүүлэв.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Ногоон дуу хоолой” нэрийн доор “Зөв мод зөв арчилгаа” уриатайгаар зохион байгууллаа.

Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгалийн ургамлын тухай, Ойн тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Усны тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах, эдгээр хуулиудтай холбогдон орон нутагт гарч буй хэрэг зөрчил, анхаарах асуудал зэргээр иргэд олон нийтэд чиглэсэн контент, постер, шторкийг бэлтгэн цахим сүлжээ, байгууллагын пэйж хуудсаар дамжуулан сурталчилах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Есөнбулаг сумын Рашаант, Халиун сумын Олонбулаг, Гүү бариач багуудад хууль бус мод бэлтгэл, ан агнуур, ургамал ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 17 айл өрхийн 51 иргэнд зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтаар:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан доор зохион байгуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 11 ажлыг бүрэн хэрэгжүүллээ.

Лифт, өргөх байгууламж бүхий аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдох асуудлаар 4 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх шалгалт хийж, дүн мэдээг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр боловсруулсан улсын байцаагчийн 10 заалт бүхий зөвлөмжийг барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1 иргэн, 4 аж ахуйн нэгжид хүргүүлэв.

Зөвлөгөө, мэдээлэл авахаар хандсан 8 иргэн, 4 аж ахуйн нэгжид холбогдох асуудлын хүрээнд хууль дүрмийг тайлбарлан, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллав.

Тэтгэврийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх шалгалтыг Есөнбулаг, Цээл, Алтай, Төгрөг, Бугат сумдад хийж ажиллав.

1 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 2 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх онд үйлдвэрлэлийн осол гарсантай холбогдуулан үйл ажиллагааг түр зогсоож, улсын байцаагчийн 10 заалт бүхий албан шаардлага хүргүүлээд байсан 1 аж ахуйн нэгжээс үйл ажиллагаа сэргээх хүсэлт ирүүлсний дагуу барилгын талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, өмнө өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг шалгаж, үйл ажиллагааг сэргээх акт үйлдлээ.

Барилга, дэд бүтцийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах чиглэлээр Есөнбулаг сумд барилга угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа 4, Цээл, Алтай, Төгрөг, Бугат сумдын барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа 5 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.

Эрчим хүчний хяналтаар:

Аймгийн Засаг даргын захирамжаар хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан орон сууцны барилга, шатахуун түгээх станцад улсын комисс ажиллаж, үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах зорилгоор үүрэг даалгавар өгч ажиллав.

Барилгын техникийн хяналтаар:

4 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Тайшир, Дэлгэр, Баянтоорой тосгон, Эрдэнэ сумдад барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд төлөвлөгөөт бус шалгалт хийж холбогдох дүгнэлтийг хүргүүлж ажиллав.

Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд 2 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт хийж, дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүллээ.

МХЕГ-аас ирүүлсэн 01-017-008/06 тоот зөвлөмжийг Тайшир, Дэлгэр, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Бигэр сумдын барилга, байгууламжийн өмчлөгч, эзэмшигч нарт хүргүүллээ..

Авто зам, тээвэр, өргөх механизмын хяналтаар:

Алтай хотын төвд хийгдэж байгаа авто замын тэмдэг тэмдэглэгээ, угсралтын ажлын чанарт 6 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Алтай хотын төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн жишиг гудамж, тохижилтын ажлын чанарт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, улсын комиссоор байнгын ашиглалтад орууллаа.

“Ухаалаг Алтай хот” хөтөлбөрийн хүрээнд такси үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд такси үйлчилгээ эрхэлдэг иргэн болон аж ахуй нэгж байгууллагад хууль дүрэм, стандартын талаар мэдээлэл өглөө.

Хүнсний чанар, стандартын хяналтаар

Иргэнээс ирүүлсэн 3 гомдлын дагуу хяналт хийж нэг иргэнд 300,0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч, 2 иргэний гомдол батлагдаагүй тул мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 3 хүсэлтийн дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэлд бүртгэж, хариуг хугацаанд нь хүргүүлэн, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах хүсэлтэй 5 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох хууль, стандартыг танилцуулав.

Аймгийн Прокурорын газрын 2022 оны 2-р улиралд хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн Прокурорын газрын дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга нарын хамтран баталсан удирдамжаар Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдаа эрхлэгч 10 аж ахуйн нэгжийг хамруулан хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.

Засгийн газрын 1111 төвд нэр бүхий иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Чандмань сумын “Хүрхрээ долгио” хоршооны бөгтөр хөх арвайн цехийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 23 заалттай албан шаардлага өгч ажиллалаа.

Эмнэлэг, эрүүл ахуйн хяналтаар:

Аймгийн нэгдсэн зарын группэд тавигдсан “Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, эмчилгээ хийнэ” гэсэн зарын дагуу хяналт хийж тусгай зөвшөөрөлгүй

үйл ажиллагаа явуулж байсан зөрчлийг таслан зогсоож, сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж ажиллалаа.

Аймгийн төвийн хүн амын ундны усны эх үүсвэр Завхан голын ус, ус нөөцлөх байгууламжийн шугамын уснаас 2 дээж авч Нэгдсэн лабораторид шинжлүүлэхэд хэрэглэгчийн цэгээс авсан усны дээж нян судлал болон үлдэгдэл хлорын үзүүлэлтээрээ MNS 900-2018 стандартын шаардлагад нийцсэн байна.

Бугат, Жаргалан, Цогт, Шарга сумын төвд баригдах “120 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ”-ний барилгын ажлын зурагт эрүүл ахуйн хяналт хийж улсын байцаагчийн зөвшөөрсөн дүгнэлт үйлдэн хүргүүлэв.

Мал эмнэлэг, мал үржлийн хяналтаар:

Чандмань, Эрдэнэ, Бигэр, Дэлгэр сумдын үхэр сүрэгт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйл ажиллагаа, явцын байдалд хөндлөнгийн хяналт хийж ажиллалаа.

Бигэр сумын Урт, Их булаг, Буудай, Хүрэмт багуудын 445 малчин өрх, Тайшир сумын 85 мал бүхий өрхийн мэдээллийг Igov.mn хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэлд бүртгэв.

Бог малын мялзан өвчний талаарх сэрэмжлүүлгийг Тонхил, Дарив, Баян-Уул, Хөхморьт, Шарга сумдын ЗДТГ-ын мал эмнэлгийн тасгийн малын эмч нарт хүргүүлж, иргэд малчдад мэдээлэл сурталчилгаа хийн ажиллах чиглэл өгөв.

Стандарт хэмжил зүйн чиглэлээр:

Шарга, Тонхил, Дарив, Баян-Уул, Хөхморьт, Жаргалан сумдын аж ахуйн нэгж байгууллагын 80 ширхэг жин, 31 ширхэг шингэн хэмжигч, 39 ширхэг даралтын аппарат монометр, нийт 150 ширхэг хэмжих хэрэгслийг баталгаажууллаа.

Есөнбулаг, Дэлгэр, Гуулин, Эрдэнэ, Чандмань сумдын аж ахуйн нэгж төрийн байгууллагуудад MNS:5021-1-2020, MNS:5140-1,2,3:2021, MNS:6395-2022 зэрэг стандартуудаар үйлчилж, 15 стандартыг худалдан борлуулж, сумдын төрийн албан хаагчдад баримт бичгийн стандартаар 5 удаагийн сургалт хийлээ.

Шарга, Тонхил, Дарив, Баян-Уул, Хөхморьт, Жаргалан сумдын 8 хүнсний дэлгүүрт тохирлын гэрчилгээний сунгалт хийж, бүтээгдэхүүн стандартын талаарх зөвлөгөө өгч ажиллалаа.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР